

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм (цаашид “Ёс зүйн дүрэм” гэх)-ийн зорилго нь цэргийн алба хаагчийн баримтлах ёс зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагыг тогтоон хэвшүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх, цэргийн алба хаагчид ёс зүйн хариуцлага ногдуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ нь Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэ дүрмээр тодорхойлогдоно.

1.3. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, байгууллагын удирдах албан тушаалтан нь өөрийн эрхэлсэн асуудлын хүрээний байгууллагын цэргийн алба хаагчийн ёс зүйн байдалд хяналт тавьж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон энэ дүрмээр хүлээсэн хэм хэмжээг сахин мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх үүргийг хүлээнэ.

1.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, байгууллага тус бүр Ёс зүйн дэд хороотой байна.

Хоёр. Ёс зүйн дүрмийн үйлчлэх хүрээ

2.1. Энэхүү дүрмийн үйлчлэлд Зэвсэгт хүчний байнгын бие бүрэлдэхүүн болох цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагч, (цаашид “цэргийн алба хаагч” гэх) хамаарна.

2.2. Цэргийн алба хаагч гадаад улсад албан томилолтоор ажиллах, гадаадын цэргийн сургуульд суралцах, энхийг дэмжих ажиллагаанд оролцох үед Ёс зүйн дүрэм нэгэн адил үйлчилнэ.

Гурав. Цэргийн алба хаагчийн ёс зүйн зарчим, хэм хэмжээ

3.1. Цэргийн алба хаагч нь ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх, ёс зүйн зөрчил гаргахгүй байхаа андгайлж “Цэргийн алба хаагчийн ёс зүйн андгай”-г өргөж гарын үсэг зурж баталгаажуулна.

3.1.1. “Цэргийн алба хаагчийн ёс зүйн андгай”:

Цэргийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэхдээ “Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм мэдлэг, хүч чадлаа зориулж, Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн дүрэм, Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахин биелүүлж, цэргийн алба хаагч нэр хүндийг өндөрт өргөж, захирах, захирагдах ёсыг эрхэмлэн дээдэлж, албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ андгайлъя.” гэж андгай өргөнө.

3.1.2. Цэргийн алба хаагчийн ёс зүйн андгай өргөх ажиллагааг нэгтгэл, анги байгууллагын захирагч, дарга, хүний нөөцийн асуудал хариуцсан албан тушаалтан зохион байгуулна.

3.2. Цэргийн алба хаагч нь үйл ажиллагаандаа Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 6.1 дэх хэсэг, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 180 дугаар зарлигаар батлагдсан “Цэргийн дотоод албаны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлд заасан зарчмыг баримтална.

3.3. Цэргийн алба хаагч нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7.1 дэх хэсэгт заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээнээс гадна дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөнө:

3.3.1. хууль ёсыг үг, үйлдэл, ёс зүй болон зан суртахуунаараа эрхэмлэн дээдэлнэ;

3.3.2. үнэнч, шударга байж, хувийн ашиг сонирхлоос ангид байна;

3.3.3. бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, батлан хамгаалах салбарын нэр хүндийг эрхэмлэнэ;

3.3.4. албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ухамсарлах, ёс зүйн хариуцлага хүлээдэг байна;

3.3.5. улс төрийн үйл ажиллагаанаас ангид байна;

3.3.6. захирах, захирагдах ёсыг сахин биелүүлнэ.

Дөрөв. Цэргийн алба хаагчид тавих ёс зүйн шаардлага

4.1. Цэргийн алба хаагч нь үйл ажиллагаандаа Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан ёс зүйн нийтлэг шаардлагаас гадна энэ дүрмийн 3.1-д заасан ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд дор дурдсан ёс зүйн шаардлагыг биелүүлэх үүргийг хүлээнэ:

4.1.1. энэ дүрмийн 3.3.1-т заасны хүрээнд:

4.1.1.а. Монгол Улсын Үндсэн хууль, батлан хамгаалахын хууль тогтоомж, Цэргийн нийтлэг дүрмүүд, Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм болон тэдгээрт нийцүүлэн гаргасан байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж байгаа эрх зүйн актыг чанд баримтлах;

4.1.1.б. хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн талаар гомдол, мэдээллийг холбогдох эрх бүхий албан тушаалтан, байгууллагад мэдэгдэх;

4.1.1.в. захирагч, даргыг асуудал шийдвэрлэхэд хуульд нийцсэн, баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэлтэй мэдээллээр хангах;

4.1.1.г. хуулиар зөвшөөрснөөс бусад ажил эрхлэхгүй байх;

4.1.1.д. кибер аюулгүй байдлыг хангах;

4.1.1.е. эрх бүхий албан тушаалтны баталсан байгууллагын хөдөлмөрийн болон дотоод журмыг чанд сахин биелүүлэх;

4.1.1.ё. Хууль ёсны шаардлага тавих, хууль бус үүрэг даалгавар гүйцэтгүүлэхгүй байх.

4.1.2. энэ дүрмийн 3.3.2-т-заасны хүрээнд:

4.1.2.а. батлан хамгаалах эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавих;

4.1.2.б. авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

4.1.2.в. цэргийн эд хөрөнгийг хадгалах, хамгаалах, зориулалтын дагуу зохистой ашиглах, хэрэглэх;

4.1.2.г. хууль бусаар бусдад давуу байдал олгохгүй байх;

4.1.2.д. албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдээс бэлэг, мөнгө, шан харамж авахгүй байх, мөн хөнгөлөлт, урамшуулал, зээл, хангамж эдлэхгүй байх;

4.1.2.е. хувийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргахгүй байх, зайлшгүй тохиолдолд дээд албан тушаалтанд мэдэгдэж зөвшөөрөл авах;

4.1.2.ё. алба, албан тушаалтны нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг цээрлэх;

4.1.2.ж. өөрийн өмчийн байдалд орсон өөрчлөлт болон хөрөнгө орлогын талаар үнэн зөв мэдээлж, ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах;

4.1.2.з. цахим гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаанд элсэх, оролцох, бусдыг оролцохыг ятгах, элсүүлэх, цахим орчинд мөрийтэй тоглохгүй байх;

4.1.2.и. мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодис хэрэглэхгүй байх.

4.1.3. энэ дүрмийн 3.3.3.-т заасны хүрээнд:

4.1.3.а. албан үүргээ гүйцэтгэхдээ хүний эрхийн мэдрэмжтэй байж, иргэд, олон нийт, бусад байгууллагатай харилцахдаа ялгаварлан гадуурхахгүй, хүнд суртал гаргахгүй байх;

4.1.3.б. албан үүрэг гүйцэтгэхдээ бусдын нэр төр, алдар хүндийг хүндэтгэх, үг, үйлдлээрээ дарамтлах, эрхшээлдээ байлгах, хавчин гадуурхахгүй, ёс бус үг хэллэг хэлэхгүй, гутаан доромжлохгүй байх;

4.1.4.в. иргэн, байгууллагатай соёлтой, ёс зүйтэй харилцах, хүндэтгэлтэй хандах;

4.1.3.г. цэргийн албаны нэр хүндийг ямагт дээдэлж, түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх;

4.1.3.д. жендерийн ялгаварлан гадуурхалт, ажлын байрны бэлгийн дарамт, шахалтаас ангид байх;

4.1.3.е. цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих;

4.1.3.ё. гадаад улс оронд үүрэг гүйцэтгэхдээ тухайн улсын зан заншлыг хүндэтгэх;

4.1.3.ж. олон нийтийн газарт мөрдөх дэг журмыг сахих, биеэ зөв авч явах.

4.1.3.з. цэргийн дүрэмт хувцсыг дүрэмд заасны дагуу цэвэр, өнгө үзэмжтэй, үлгэр жишээ өмсөж хэрэглэх;

4.1.3.и. байгууллагын дотоод журамд заасан хувцаслалтын шаардлагыг баримтлах;

4.1.3.й. ажлын байранд бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэх;

4.1.3.к. албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон цэргийн дүрэмт хувцас өмссөн үедээ согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгүй байх.

4.1.3.л. байгууллагын үйл ажиллагааг мушгин гуйвуулах, хамт олны эв нэгдлийг хагарган бутаргах, үндэслэлгүй худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг үндэслэлгүйгээр гүтгэх, нэр хоч өгөхгүй байх.

4.1.4. энэ дүрмийн 3.3.4-т заасны хүрээнд:

4.1.4.б. албан тушаалын үүргээ мэргэжлийн түвшинд бүрэн хариуцах;

4.1.4.в. ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд өөрийн үйлдэлдээ дүгнэлт хийн хүлээн зөвшөөрч, сайн дураар хариуцлага хүлээх чадвартай байх.

4.1.5. энэ дүрмийн 3.3.5-д заасны хүрээнд:

4.1.5.а. улс төрийн үйл ажиллагаа эрхэлдэг аливаа байгууллагын үйл ажиллагаанд нэгдэх, оролцохгүй байх;

4.1.5.б. улс төрийн үйл ажиллагаа зохион байгуулахгүй байх;

4.1.5.в. захирагч, даргын зөвшөөрөлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцохгүй байх;

4.1.5.г. албаны үйл ажиллагаатай холбогдох асуудлаар хэвлэл мэдээллийн байгууллагад удирдлагын зөвшөөрлөөр мэдээлэл өгөх;

4.1.5.д. хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон цахим орчинд батлан хамгаалах, зэвсэгт хүчний үйл ажиллагаатай холбогдох асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх.

4.1.6. энэ дүрмийн 3.3.6-д заасны хүрээнд:

4.1.6.а. захирагч, даргын хуульд нийцсэн тушаал, шийдвэр, үүрэг, даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх;

4.1.6.б. төрийн бодлого, хууль тогтоомж, захирагч, даргын тушаалыг эсэргүүцэхгүй байх;

4.1.6.в. захирагдагчдынхаа өмнө нэр хүнд, ажил хэргийн үлгэр жишээг үзүүлэх;

4.1.6.г. хамт олноо манлайлах, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, бусдад зөв үлгэр дуурайлал үзүүлэх;

4.1.6.д. олон нийт, байгууллага, хамт олны дунд эерэг, зөв хандлага төрүүлэх;

4.1.6.е. хүний хувийн мэдээлэл болон эмзэг мэдээллийг хуульд зааснаас бусад байдлаар ашиглах, тараах, задруулахгүй байх;

4.1.6.ё. албан тушаал, цолны эрэмбээр хоорондоо дүрмийн дагуу харилцах;

4.1.6.ж. удирдлага, байгууллага, хувь хүн, ажлын байрны соёлыг сахих;

4.1.6.з. албан бус мэдээ, мэдээлэлд үндэслэн аливаа шийдвэр гаргахгүй байх;

4.1.6.и. хуульд заасан цэргийн алба хаагчийн эрхийн хязгаарлалтыг тус тус баримтална.

Тав. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх

5.1. Ёс зүйн дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтан нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан арга хэмжээ болон цэргийн алба хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тодорхой, үр дүнтэй ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, холбогдох эрх бүхий байгууллагад хуульд заасны дагуу тайлагнана.

5.2. Цэргийн алба хаагчийн ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзана.

Зургаа. Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх

6.1 Ёс зүйн зөрчил гаргасан тухай өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх ажиллагааг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу зохион байгуулна.

Долоо. Цэргийн алба хаагчид ёс зүйн хариуцлага ногдуулах

7.1. Цэргийн алба хаагчийн ёс зүйн зөрчил гэж Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 5.1.2-т зааснаас гадна цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно.

7.2. Энэ дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн цэргийн алба хаагчид тухайн байгууллагын Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан ёс зүйн хариуцлага ногдуулна.

7.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасны дагуу тухайн байгууллагын Ёс зүйн дэд хорооны дүгнэлтээр тухайн цэргийн алба хаагч ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол түүнд албан ёсоор мэдэгдсэнээр хариуцлагыг сайн дураараа хүлээх боломж олгоно.

7.4. Цэргийн алба хаагч нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасан ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээж болно.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ